

ҮЗЭЛ БОДОЛ

БАРИЛГЫНХНЫГ
ЗӨНГӨӨР НЬ ОРХИОЧ ЭЭ

III нүүрт

ОНИЦЛОХ ХУУДАС

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Э.БАТ-ҮҮЛ: С.ЗОРИГИЙН ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙГООР НАМАЙГ ХОРЬЖ БОЛЗОШГҮЙ БАЙНА

Дугаарын 60 мөр

Цэцэрлэгийн багш
нарт сануулах зүйл
байна

Х.НОРЖИН



үед юу ч мэдээгүй учир олон түмэнд мэдээлэл өгч чадалгүй баригдаад явж байсан. Гэтэл одоо дахиад ийм нөхцөл байдал үүсч болзошгүй болоод байна” гэдгийг мэдээллийн эхэнд дуулгаж байлаа.

Хэргийн газарт
малгайгаа мартсаныг
ТОГТООСОН

Олон жил өнгөрч байгаа учир тухайн үед юу болсон түүхийг ярих нь зүйн хэрэг байх. Тэгвэл өнөөдөр юу болж байгааг ойлгоход амар байна гэж бодож байна. 1998 оны намар С.Зоригийг зэрлэгээр хөнөөсөн. Хэрэг гардаг орой гэртээ сууж байхад нийслэлийн цагдаагийн дарга Н.Ганболд намайг хамгаалалтад авч байна гэж хэлээд, хэрэг болсон газарт дагуулан очиж байсан. Очиход олон хүн бужигнаж байсан. Хамгийн сонирхолтой нь хэргийн газрыг огтоос хамгаалалтад аваагүй. Бөөн хүн бужигнасан газарт намайг авч очсон. Тухайн үед би бусадтай адил цочирдсон. Тэгээд Ц.Элбэгдоржийг ирэхэд нь хамт тэндээс гараад явсан. Харин гарахдаа малгайгаа мартаад гарсан байсан.

Үргэлжлэл нь II нүүрт

“Хүн хэлэхээс, цааш чичихээс нааш” гэж өвгөдийн мэргэн үг байдаг даа. Тэр утгаар цэцэрлэгийн багш нарт хандан өөрт тохиолдсон зүйлээр жишээ аван сануулж, анхааруулах гэсэн юм. Өнгөрсөн баасан гарагт цэцэрлэгийн бага ангид элссэн зээ охиноо авах үүрэг надад ногдлоо. Энэ тухай өвөөд нь дуулгахад тэрбээр “Би хамт явж, зээгээ авна. Ер нь та нар ямар цэцэрлэгт өгснийг нь очиж харна” хэмээн сүржигнэв. Үрийн үрийг аминаасаа ч илүү хайрладаг нь хүний хорвоогийн хамгийн сайхан зүйлүүдийн нэг байдаг юм хойно доо. Ингээд л эмээ, өвөө нь хоёр талаасаа уулзалдан “Заавал эцэг эх хоёрт нь өгч явуулдаг журамтай гээд өгөхгүй байвал яана аа. Хүргэн цэцэрлэгтэй гэрээ байгуулахдаа “Эцэг эх хоёроос гадна ийм ийм хүмүүс авч болно гээд хоёр талын эмээ өвөөгийнх нь нэрсийг өгсөн байх ёстой” гэхчилэн элдэв таамаг дөвшүүлсээр цэцэрлэг дээр ирлээ.

Үргэлжлэл нь II нүүрт

Ж.ОТГОН

С.Зориг агсны хэрэгт холбогдуулан Нийслэлийн Ардчилсан намын дарга Э.Бат-Үүлийг яллагдагчаар татсан байна. Тэрбээр энэ талаар “Өнөөдөр намайг олон жилийн дараа дахин

С.Зоригийг зэрлэгээр хөнөөсөн хэрэгт яллагдагчаар Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчиж, дахин холбогдуулах үйл ажиллагаа эрч хүчээ аваад байна. Намайг хууль зөрчиж, хорихыг хүртэл шаардаж байгаа талаар мэдээлэл аваад

байгаа. Тиймээс тун удахгүй хорих хүртэл нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа учир та бүхэнд энэ талаар мэдээлэл өгөхийг хүссэн юм. Намайг ямар ч гэмгүй байхад 2000 онд хуулийн наад захын шаардлагуудыг зөрчин ганц худагтааваачиж, хорьж байсан. Битухайн



ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 5000 SERIES



БИД ТАНЫ АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛНӨ

Inspiron 15 5000 загварын нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан Full HD дэлгэц, гайхалтай график үзүүлэлт, Intel® Core i5 процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

Онцгой урамшуулал

Dell брэндийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.



Бэлгэнд

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусын програм

www.facebook.com/PCmallOfficial
www.instagram.com/PCmall_Official

Биднийг дагаарай 7575-3535

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8

ХААН банк					Худалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2228.00	2243.00	ФУНТ	2907.00	3000.00	АМ.ДОЛЛАР	2226.00	2243.00	ФУНТ	2922.00	3015.00
ЕВРО	2469.00	2552.00	РУБЛЬ	33.20	36.10	ЕВРО	2475.00	2555.00	РУБЛЬ	33.32	36.40
ИЕН	21.48	22.05	ЮАНЬ	332.00	336.50	ИЕН	21.45	22.22	ЮАНЬ	332.00	336.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР



Э.БАТ-ҮҮЛ: С.ЗОРИГИЙН ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙГООР НАМАЙГ ХОРЬЖ БОЛЗОШГУЙ БАЙНА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэтэл уг хэрэг явдлын дараа надаас гэрчийн хувьд мэдүүлэг авсан. Тэгээд “малгайгаа мартсан байсан нь тогтоодсон” хэмээн Мөрдөн байцаагч н.Цогтбаяр малгайг минь өгсөн. Үүнээс хойш надаас дахин мэдүүлэг, байцаалт аваагүй. Харин 2000 оны УИХ-ын сонгуулийн өмнө дөрөвдүгээр сарын үед Мөрдөн байцаагч н.Цогтбаяр дахин дуудаад “нөгөө малгайг минь аваад л “энэ малгай хэргийн газраас олдсон учир сэжигтнээр татаж байна” гэсэн. Нөгөө “малгайгаа мартчихсан байсан нь тогтоогдлоо” гээд надаа өгчихсөн байсан малгайг хоёр жил гаруй хугацааны дараа буцааж аваад, сэжигтнээр татаж байна гэж байсан. Улмаар энэ үед энэхүү хэрэгтэй холбоотойгоор улс төрийн компаниг ажил явуулсан. Бүр маш хүчтэй

компаниг ажил явуулсан. Сонин хэвлэлээр намайг яаж гүжирдэж, гүтгэж, доромжилж байсныг бүгд мэдэж байгаа байх.

МАН-ынхан
С.Зоригийг минь
алчихлаа...

Тухайн үед миний сонгуулийн тойрогт олон мянган хувь хэвлээд ном тараасан. Энэхүү номыг н.Дожоодорж гэдэг хүн бичсэн. Тэр бол Өнөрмалгийн хэрэг, Алтан цөгцний хэргүүдээр шуугиулж байсан хүн. н.Дожоодорж “С.Зоригийг Засгийн газрын ордны цонхор шээсэн” гэдэг шугианыг дэгдээж байсан. Гэтэл энэ хүн сонгуулийн өмнө “Ардчилсан хувьсгалын удирдагчийг хэн хөнөөсөн бэ” гэдэг ном гаргасан. Энэ номондоо намайг маш ихээр гүжирдэж, гүтгэсэн. Номыг нь би олж аваад байгаа. Энэ номонд “С.Баяр танаа... танд болон танай гэр бүлд аз жаргалын дээднийг ерөөж, өчүүхэн номоо барив... н.Дожоодорж 2000.07.26” гэдэг яг сонгууль болохын өмнө бичсэн байдаг. Тухайн үед энэ номыг маш олноор нь миний тойрогт тарааж байхтай таарч, авч байлаа. Ер нь энэ хэрэг гарсаны дараа “улстөрүүлж болохгүй шүү” гэдгийг хамгийн анх би уриалж байсан. Учир нь хэргийн ул мөр бүдгэрнэ, жинхэнэ хэрэг хийсэн хүн улстөржүүлэхээр олохгүй байх аюултай. С.Зоригийг бүрэлгэсний маргааш өглөө нь намайг намынхаа байранд очиход, олон мянган хүн төв шуудангийн өмнө цугларчхсан “МАН-ын цагаан байр руу дайръя. МАН-ынхан С.Зоригийг минь алчихлаа” гэж байсан. Тухайн үед би цугларсан олон мянган хүний өмнө гараад, “Ингэж болохгүй. Энэ хэргийг улстөржүүлж л болохгүй шүү. Үндэслэлгүйгээр бие биенийг гүжирдэж болохгүй. Та бүхэн тайван байцгаа” гэж хэлсэн. Тэр үед хүмүүс миний үгийг л чагнаж байсан. Хэрвээ би цагаан байр руу хуруугаа заасан л бол аюул болох байсан. Бүр “Наад хүмүүсээ МАН-ын цагаан байр руу дайруулаач” гэж зарим хүмүүс намайг турхирч байсан. Харин би хүмүүст “би Монголын ард түмнийг хэзээ ч ийм муухай үймээн, самуун, хүчирхийлэл рүү үндэслэлгүйгээр түлхэхгүй” гэдгийг хэлсэн. Тиймээс ч цугларсан хүмүүс миний үгийг

сонсоод, эмгэнэл илэрхийлчн хээд, тарж байлаа. Энэ үеэр Үндэсний олон нийтийн телевизээр МАН-ынхан С.Зоригийг алсан гэдэг яриа хөөрөө, бичлэг, ард иргэдийн санал бодлыг сонссон нэвтрүүлэг явсан. Би телевиз дээр нь очоод “Ингэж бие биенийг гүжирдэж болохгүй. Энэ хэргийг ингэж улстөржүүлж болохгүй. Хэргийн жинхэнэ эзэн олохгүй болчихно” гэдгийг хэлж байсан. Үндэслэлгүйгээр гүжирдэж болохгүй гэж хэлсний минь төлөө н.Дожоодорж номондоо “Э.Бат-үүл МАН-ынхан гэж мэдэж байгаа юм бол хэн хөнөөснийг нь мэдэж байгаа” гэж бичсэн. Гэтэл тун удалгүй МАН-ынхан энэ хэргийг хийсэн гэдгээ болнод Ерөнхийлөгч Н.Багабанди хөнөөсөн гэсэн утга бүхий нэвтрүүлэг телевизээр цацагдаж эхэлсэн. Энэ үед би дахиад л телевиз дээр очиж “Үндэслэлгүй гүжирдэж болохгүй” гэдгийг хэлж байсан. Энэ мэт миний зүтгэлийн дүнд бид талбай дээрээ том цуглаан хийж, талийгаачийгаа сүүлчийн замд нь үдсэн. Хэрвээ би ийм арга хэмжээ аваагүй бол тэр үед улс орон хүчирхийлэл рүү хальтрах байсан гэж би боддог юм. Битгий улстөржүүлэх гээд байхад л МАН-ынхан 2000 оны сонгуулиар миний эсрэг “Э.Бат-үүл С.Зоригийг алсан” гээд хамгийн том улс төр болгосон. Харин сонгуулийн үр дүнд МАН яг өнөөдрийнх шиг маш том ялалт байгуулсан. Миний хэлдгээр “Цунами” шиг том ялалт дараа наймдугаар сард нь ямар ч хийгээгүй хэргийн төлөө намайг аваачиж хорьсон. Би хүнд гар хүрээгүй байхад, хүн зодсон гээд аваачаад ганц худагт хорьчихсон. Гэтэл түүнийг прокуророос хүчингүй болгосон. Мэдээж шүү дээ, ямар ч хийгээгүй хэргийн төлөө хүнийг шууд хорьчихсон юм чинь. Ингэхдээ н.Амарболдын даалгавараар намайг хорьсон мөрдөн байцаагч н.Цогтбаяр тухайн үед хошууч цолтой байсан. Намайг хорьсонхоо дараа цол нэмж Дэдхурандаа болсон. Яагаад н.Амарболдын даалгавараар хорьсон гэхээр тухайн үед н.Амарболдыг цагдаагаас чөлөөлөх шаардлагыг их тавьдаг байсан. Учир нь н.Амарболдын үед рецидив гэмт хэрэгтнүүд хүчээ авчихсан, нийгэм айдас автчихсан байлаа. Айдатгүй үгээ хэлдэг хүн нь би л байсан. Ийнхүү МАН

манай намыг сонгогчид бид С.Зоригийг хэргийг илрүүлнэ гэж байгаад сонгуульд ялсан. Үүний дараа намайг гүтгэж, гүжирдэж хороод, түүнийг нь удаа дараа прокуророос хүчингүй болгосон. Үүнээс хойш энэ хэргийн талаар дахиж асуугаагүй, яриагүй. Харин би энэ бүхний дараа С.Оюунд хэлж байсан “Гаднаас өндөр зэрэглэлийн мөрдөгч авч ирэх хэрэгтэй. Олон улсын байгууллагын дэмжлэг авъя” гэдгийг хэлж байсан. Хэрэг гарсан даруйд ч Ц.Элбэгдоржид, Д.Дорлигжавд ч үүнийг хэлж байсан. Ер нь гэмт хэргийн газрыг хамгаалалтад авахгүй, олон хүн

нууцын зэрэглэл тогтоохчхсон байгаа юм. Өөрөөр хэлбэл, “маш нууц” болгож байгаа нь бүх үйл явцыг хаалттай хийнэ гэсэн үг. Гэтэл нууцын тухай хууль гэж байдаг. Хуулиар хэн дуртай мөрдөн байцаагч нь нууцын зэрэглэл тогтоодоггүй. Тиймээс би сэжигтний тогтоолыг нь зөвшөөрөөгүй. Гэтэл хууль зөрчиж хийсэн тогтоолынхоо дагуу намайг С.Зоригийн хэргийн яллагдагчаар татсан. Би яллагдагчаар мэдүүлэг өгөхгүй гэсэн. Учир нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар би мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй. Өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Намайг хууль бусаар байцаан

бужигнуулчихсан байж байгаа хүмүүст яаж итгэх юм. Гэтэл цагдаагийн байгууллага зөвшөөрөхгүй байна гээд явж өгөөгүй.

16 жилийн дараа
дахиад намайг
яллагдагчаар татаж
байна

Сая болсон сонгуулийн өмнө сонин болон сайтууд дээр намайг дахин гүжирдээд эхэлсэн. Тухайлбал, “Ц.Элбэгдорж ямар хүнд Улсын баатар өгчихөв өө гэж дороо дэвхцэн, хашгирчээ” гэдэг зүйлийг гаргаад ирсэн. Мөн “17 жил бугшсан С.Зоригийн алага илэрлээ” гээд энэ удаад намайг алсан биш. Алах үед нь хажууд нь хараад байж байсан гэсэн зүйлийг бичих болсон. Үүнийг би порокурорт шалгуулахаар өгчихсөн байгаа. Гэтэл шалгаж өгөхгүй байна. Гайхалтай. Хүнийг онц ноцтой гэмт хэрэгт холбогдуулан “хүн алж байхад, хажууд нь хараад сууж байсан” гэж гүжирдээд байхад шалгаж өгөхгүй байна. Одоо сонгуулийн дараа буюу 16 жилийн дараа бараг ойн дээрээ дахин асуудал сөөхөгдөж байна. Саяхан З.Энхболд дарга бид хоёр “МАН-ынхан АН-ыг эдийн засгийг хямруулсан гэж гүжирдэж байна. Ингэж гүжирдэх гэж байгаад Монгол Улсыг хүнд байдалд орууллаа” гэж хэвлэлийн бага хурал хийсэн. Хурлаас гараад амралтын газарт байж байтал эхнэрийн утас руу утасдсан. Улмаар Тагнуулын газраас надад мэдэгдэх хуудас авч ирж өгсөн. С.Зоригийн хэрэгтэй холбоотойгоор таныг дуудаж байна гэсэн. Тэгээд яваад очтол дахиад гаргачхсан байсан. Энэ нь Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байхгүй жишиг тогтоож байгаа хэрэг. Нэг хэрэгт нэг асуудлаар хоёр удаа сэжигтнээр тогтоол гаргадаг зүйл Монгол Улсын хуульд байхгүй. Би одоо хоёр тогтоолтой болсон. Яагаад хоёр тогтоол байгаа юм бэ. Ядаж өмнөх нь хууль зөрчсөн юм бол нэгийг нь болуулаад, шинээр тогтоол үүсгэх учиртай гэдгийг хэлсэн. Гэхдээ нийтийн мэдэх буюу 16 жилийн өмнөх тогтоолыг “маш нууц” гэхийнх байгаа юм. Харин шинэ тогтоол нь “нууц” гэсэн зэрэглэлтэй байна. Зүгээр нэг мөрдөн байцаагч дураараа

шийтгэх үйл ажиллагаа явуулах гэж байгаа бол хуулийн дагуу би мэдүүлэг өгөхгүй байж болно гэсэн үг.

Би С.Зоригийн
хэргийн учир нь
олдоосой гэж өдөр
бүхэн залбирдаг

Би энэ хэргийг анхнаасаа илрүүлэхийн төлөө явсан. Он жил өнгөрөх тусам би илрүүлэхийг бүр ч ихээр хүсэх болсон. Яагаад гэвэл би хамгийн их хэлмэгдэж хохирч байгаа хүн. Э.Бат-үүл олон түмэнд худалдаа, ер нь юу ч хийж мэдэх хүн гэдэг имижтэй учир түүнийг энэ хэрэгт холбох нь илүү амар гэж тооцоолдог байх. Тиймээс би нэр төрөө цэвэрлэж авахыг үнэхээр их хүсдэг. Би С.Зоригийн хэргийн учир нь олдосой гэж өдөр бүхэн залбирдаг. Өөрийн зүгээс бололцоотой бүх дэмжлэгийг үзүүлсээр ирсэн. Одоо ч үзүүлдэхэд бэлэн. Намайг шалгах ёстой бол шалгуулах болно. Гэхдээ хуулийн дагуу шалгуулна. Учир нь хууль зөрчиж байна гэдэг чинь өөр зорилготой л гэсэн үг. Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиараа л яв. Хэрвээ хуулийн дагуу бол намайг сэжигтнээр, яллагдагчаар татаж болно. Бүр хорьж ч болно. Хүнийг хуулийн дагуу хэлмэгдүүлэхийн зовлонг бид 1930-аад онд үзсэн. Хууль зөрчиж байна гэдэг чинь хэлмэгдүүлэх гэж байгаа гэсэн үг. Улс төрийн зорилготой буюу удаа сонгуультай уялдуулдаг. Би бодож байна. Магадгүй энэ удаагийнх Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой байх. Өнгөрөн баасан гарагт энэ хэрэг болсноос хойш анх удаа надаас хурууны хээ, үс, цусны шинжилгээ авсан. Өмнө нь хэзээ ч ингэж авч байгаагүй. Харьцуулсан шинжилгээ юм гэсэн. Хууль бусаар яллагдагчаар татсан гэх тогтоолынхоо дараа ийнхүү шинжилгээ авч байгаа нь хачин. Яллагдагчаар татна гэдэг чинь хэргийг нотлох хангалттай үндэслэлтэй үед л яллагдагчаар татдаг. Гэтэл яллагдагчаар татчихсан хойноо батлах, нотлох зүйл хайгаад явж байна. Энэ чинь юу болж байгаа юм бэ. Намайг одоо байцааж байгаа мөрдөн байцаагчид дээрээс нь “наад хүнээ хорь” гэдэг дарамт үзүүлж байна. Тиймээс ч би энэ бүх мэдээллийг олон нийтэд хүргэх нь зүйтэй гэж бодсон юм.

МЭДЭЭЛЭЛ

“60 тэрбум”-ын бичлэгийн хэргээр хоёр иргэнийг шалгаж эхэлжээ

МАН-аас сонгуулийн дараа хүсэлт гаргасны дагуу хуулийн байгууллагынхан тус намын удирдлагуудтай холбогдох 60 тэрбум төгрөгийн тухай бичлэгийн хэргийг шалгаж байгаа аж. Тэгвэл уг асуудлыг АТГ-аас хэргийг шалгаж дууссан бол гэмт хэргийн шинжтэй зүйлийг цагдаагийн байгууллага шалгаж эхэлжээ. Шалгалтын явцад уг хэрэгт холбоотой хоёр иргэнийг тогтоож, сэжигтнээр татсан байна. Тэднийг эвлүүлж хийсэн, далайлган сүрдүүлсэн, бусдыг гүтгэсэн гэдэг үндэслэлээр нийслэлийн Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст эрүү үүсгэн байцааж байгаа юм байна. Сонгуулийн үеэр буюу өмнө нь АН-ын удирдлагууд уг

Хоёр яамны төрийн нарийн бичгийн дарга тодорхой боллоо

Төрийн албаны зөвлөлөөс зарим яамдын төрийн нарийн бичгийн дарга нарыг томилох тухай асуудлыг нээлттэйгээр зарлах болсноо мэдэгдсэн билээ. Уг албан тушаалд ажиллах сонирхол бүхий иргэдийг сонгон шалгаруулах шалгаруулалт өчигдөр явагдсан байна. Одоогийн байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргаар

бичлэгийг шалгуулах хүсэлтийг АТГ-т гаргаж байсан юм. Тухайн үед МАН-ын дарга М.Энхболд, нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуй, зөвлөх А.Ганбаатар нарын хооронд өрсөлон гэгдэх төрийн албыг худалдаж ашиг болгон үнэлэх, зөвхөн нийслэлд 60 тэрбум төгрөг босгох тухай утасны яриа, бичлэгийг шалгуулахаар Шүүхийн шинжилгээний

үндэсний хүрээлэнд хандсан байдаг. Харин Шүүхийн шинжээчид бичлэгийг хянаж, шинжлэх явцад тэрхүү бичлэг дэх албан тушаалтнуудын яриа нь тэднийх биш, эвлүүлэг хэмээсэн. Тиймээс АТГ энэхүү шинжээчийн дүгнэлтэд үндэслэн МАН-ын удирдлагуудтай холбогдох 60 тэрбум төгрөгийн тухай бичлэгт эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан юм.

эдийн засагч, Ч.Хашчуун, БХЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар А.Батбилэг нар сонгогдох нь тодорхой болжээ. Энэ хоёр яамнаас гадна Гадаад харилцааны яам, Хууль зүй,

дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга нар тодрох учиртай.

Дугаарын **60** мөр

Цэцэрлэгийн багш
нарт сануулах зүйл
байна

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Цэцэрлэгийн багачууд 16:30-ийн цайгаа уугаад дуусч байгаа бололтой, аяга таваг хураах, багш нарын “чимээгүй, өөр өөрийн сандал дээр суцгаа. Хэн томоотой сууна, тэр хүүхдийн ээж, аав нь хамгийн түүрүүнд ирж авна” хэмээн сэтгэхүйн “дайн” зарлаж байгаа нь хаалганы цаана сонсогдоно. Өвөө нь “Нархан” бүлгийн хаалгаар шагайн “Уянгыг авъя” гэвэл “Уянга яваарай” гэнцхээд таг болов. Бяцхан зээ минь ч тэгсхийгээд гарч ирээд тав хоног уулзаагүй эмээ, өвөө хоёроо хараад баярлахдаа нэг уйлах маяг үзүүлснээ “гадаа” хэмээгээд хүзүүгээр тэвэрлээ. Бид гурав хувцсаа солих гэж үүдний өрөөнд хэсэг бөвтгөнөсөн ч хоёр багшийн хэн нь ч гарч ирж бидэнтэй уулзаж ярилцсангүй, үдэж ч гаргасангүй. Зээгээ орой тарахад нь бид хоёрын хэн нэг нь өмнө авч байсан бол “зүс таных юм” гээд өгөөд явуулж болох юм. Гэтэл үгүй. Анх удаагаа авч байгаа нь тэр. Асуудал эндээс л үүдэлтэй. Таныг, мэдэхгүй, урьд өмнө нь харж байгаагүй хүмүүст нэрийг нь хэлэх гөдийд өгөөд явуулж байгаа нь цэцэрлэгийн багш нарыг эрхэлсэн ажилдаа харууцлагатай ханддаг гэж дүгнэж болохгүй байгаа биз дээ. Хичээлийн шинэ жил эхлээд дөнгөж 10 гаруйхан хонож байна. Цэцэрлэгийн эрхлэгч нар цаг алдалгүй, эцэг эх, эмээ өвөө болоод онцгой тохиолдолд хүүхдийг нь цэцэрлэгээс авах хүмүүсийнх нь судалгаа авч, эцэг эхээс нь өөр хүн ирж авсан тохиолдолд “ийм хүн авлаа” гэх мэдээллийг тэр дор нь өгдөг тогтооллоонд шилжих цаг болжээ. Далхий дахинд бага насны хүүхэд хэдэн арван мянгаараа ор сураггүй алга болж байгаа ийм цаг үед ялангуяа, цэцэрлэгийн насныханд маш харууцлагатай хандаж, гараас гарт хүлээлгэн өгөх учиртай бус уу. Азаар Монгол Улсад л хүүхэд ор сураггүй алга болсон тухай дуудлаагүй болохоор л багш, эцэг эхчүүд энэ асуудалд төдийлөн анхаарал хандуулж ирээгүй бололтой. Үүний жишээ бол миний зээ охины хүмүүжиж буй цэцэрлэг. Нөгөөтэйгүүр, сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод шинээр сүндэрлэн боссон том том хотхон, хорооллууд хүүхдийн цэцэрлэгийн асуудлыг давхар шийдэж ирснээр хэдэн арван байшингийн булан өнгөрч байж хүүхдээ цэцэрлэгт өгдөг байх үе зарим талаар мартагдаж буй гэж хэлж болно. Нөхцөл байдал сайжирсан болоод тэр байх, зарим залхуу нь дэндсэн эцэг эхчүүд хүүхдээ хувцаслаж өгөөд гүйлгэхийг нь бий. Бас гэр нь ойрхон юм гээд өөрөө дэгдээд харьчих гээд хувцаслаж өгөөд гэр рүү нь явуулчихдаг багш нар ч байдаг. Үнэндээ хайхрах эзэнгүй бяцхан хүү булан тойрох гэж харайлгаж яваад автомашины осолд орвол хэн хохирох билээ, хүүхэд, Эдүгээ Монгол Улсад өдөрт 7-8 даа насны хүүхэд эцэг эхийн анхаарал суларснаас осолд орж, амь нас эрүүл мэндээрээ хохирч буй нь ч эцэг эх, багш нарын анхаарал халамжтай холбоотой асуудал. Ниргэсэн хойно нь хашгирч элдэв болохоосоо өмнө болзошгүй аюулаас бяцхан үрсээ хамгаалах нь хаа хаана аа харууцлага байж мэднэ. Эрхэм цэцэрлэгийн багш нараа та бүхний анхаарлаа сарниулсан нэг хором бяцхан үрсийг минь аюулгүй нөхцөл рүү түлхэж байвал яана.

ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Õàḍààḍàè
 ò¿ì ¿¿ñ ÿàãàä
 íîì óíøääã¿éã
 àè î ééãî äî ãã¿é

А.Сайханцэцэг

ҮЗЭЛ БОДОЛ



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

БАРИЛГЫНХНЫГ ЗӨНГӨӨР НЬ ОРХИОЧ ЭЭ

...Тэгвэл одоо сардаа 600-700 мянган төгрөг төлчих боломжтой хүмүүс рүү хандсан бодлого хэрэгжүүлэх цаг болсон юм биш үү. Өөрөөр хэлбэл, таван жилийн хугацаатай хүүгүйгээр төлбөрөөр төлөх нөхцөлтэй байж болно. 60-70 саяын үнэтэй 40 орчим ам.метр байрыг ийм хугацаанд хуваагаад төлчих боломжтой өрх гэр бас байж л байгаа...

харж үнэг турж үхэв” гэдэг шиг юм болох вий дээ. Түүний оронд өөрсдөө энэ хүндрэл, бэрхшээлийг давах гарц хайвал яасан юм.

Үнээ бууруул

Нэг үеэ бодвол орон сууцны ам.метрийн үнэ хямдарч байгаа гээд л байгаа. Гэвч яг начир дээрээ буурсан юм алга. Барилгын салбарынхан хямраагүй юм шиг л үнээ буулгахгүй гүрийд байна. Юун 20 мянган байр эзнээ хүлээх. Худлаа юм биш үү. Үнэхээр зарагдахгүй байгаа бэлэн орон сууц тийм их байгаа бол орон сууцны үнэ дунджаар хоёр сая руу орох ёстой биз дээ. Гэтэл өнөөдөр орон сууцны үнэ дунджаар ам.метр нь 2.4 сая төгрөг байна. Гэтэл барилгын салбарын өнгөрсөн долоо хоногт чуулахдаа орон сууцны нэг ам.метрийг 900 мянган төгрөгөөр босгож байгаа гэж өөрсдөө хэлсэн байна билээ. Гэтэл зах зээл дээр хамгийн багадаа 1.2 саяаас цаашлаад 3-4 сая хүргэлх төгрөгөөр зарж байна. 1.2 сая гэдэг бол төлбөрөөр 100 хувь бэлнээр өгсөн тохиолдолд л үйлчлэх үнэ. Тэгээд хотын захын орон сууцанд шүү. Өнөөдөр шууд 40-50 сая төгрөг гаргаад, төлбөрөөр бэлэн төлөөд байранд орчих хүн Монголд хэд билээ. Байгаа л даа, гэхдээ тэд аль хэдийн орон сууцтай болчихсон. Нөгөө талаар боломжтой хүмүүс хэзээ ч хотын захад, бүх юмнаасаа хол

газар байр авахгүй л байхгүй юу. Хүн бүрийн сонирхож байгаа, арай нэг төвдөө ойр орон сууцны үнэ ам.метр нь 1.8-2.0 сая төгрөг байна. За тэгээд хотын төвдөө бол дийлдэхгүй. Ийм байхад яаж бага, дунд орлоготой иргэд байранд орох хэрэгцээгээ хангаж, бэлэн болчихоод байгаа орон сууц зарагдах вэ дээ.

Барилгачдаас хэрэглэгч рүү

Өнөөдөр орон сууц авах гэж байгаа иргэд арилжааны банкнаас найман хувийн зээл авч байгаа. Олон жилийн хугацаатай, маш өндөр шалгууртай. Өнөөх зээл авахааргүй баян гэдгээ баталж байж зээл авдаг гэдэг шиг. Яахав, банкууд эрсдэлгүй л ажиллах гэдэг биз. Тэгвэл одоо тэр банкны шалгуурыг чинь давах хүн олдохоо болилоо. Тиймээс барилгын компаниуд өөрсдөө шууд хэрэглэгч рүү хандсан хөтөлбөр гаргаж, бодлого хэрэгжүүлэх цаг болсон юм биш үү. Тухайлбал, “Эко констракшн” компани гэхэд гурван жилийн хугацаанд төлбөрөө хүүгүйгээр хувааж төлөх нөхцөлтэйгээр орон сууцаа борлуулж байна. Мэдээж ийм аргыг хэрэглэж байгаа компани цөөнгүй бий. Эхний ээлжинд 30 хувиа төл, тэгээд 20, 30, 20 гэдэг ч юм уу. Янз бүрийн л арга хэрэглэж байна. Энэ мэт бодлогууд зарим хүмүүст тун таатай байгаа. Зарим гэдэг нь, харьцангуй орлого сайтай,

сардаа 1.5-2.0 сая төгрөг өлхөн төлчих боломжтой хүмүүс гэсэн үг л дээ. Тэгвэл одоо сардаа 600-700 мянган төгрөг төлчих боломжтой хүмүүс рүү хандсан бодлого хэрэгжүүлэх цаг болсон юм биш үү. Өөрөөр хэлбэл, таван жилийн хугацаатай хүүгүйгээр төлбөрөө төлөх нөхцөлтэй байж болно. 60-70 саяын үнэтэй 40 орчим ам.метр байрыг ийм хугацаанд хуваагаад төлчих боломжтой өрх гэр бас байж л байгаа. Цаашлаад барилгын компаниуд өөрсдөө жилийн 3-5 хувийн хүүтэй зээл өгч бас болно шүү дээ. Магадгүй урьдчилгаа нь 10 хувь байсан ч болно. Ийм зээлд эрсдэл гэж бараг байхгүй. Тухайн хүн зээлээ төлж дуусгал байрны гэрчилгээ компанийн мэдэлд байж байх юм чинь. Тэгээд ч нэгэнт орон байртай болсон хүмүүс яаж ийж байгаад сардаа хэдэн төгрөг төлөөд байж чадна. Сард 400-500 мянган төгрөг төлөөд, байр хөлсөлж байгаа залуу гэр бүл өнөөдөр Улаанбаатараар дүүрэн байна. Тэд байр хөлсөлж дийлээд байгаа юм чинь лизингээ дарж чадалгүй л яахав. Тиймээс одоо заавал ипотекийн зээлийн санхүүгийн эх үүсвэр баттай болохыг хүлээж суулгүй өөрсдөө гарц хайж, гарч олсон нь илүү боловсролгүй болгож, бага, дунд орлоготой иргэд рүү чиглэсэн нь дээр юм биш үү. Хажуудаа ББСБ байгуулчихаад ажиллаж байгаа компани ч байж л байна. Хэрвээ энэ бүхэн хамаагүй гэвэл эдийн засаг сэргэтэл байраа хав дараад л байж байхаас өөр яахав.

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын тэргүүлэгч салбарын нэг нь барилга. Тэгвэл тэргүүлэгчдийн эгнээнд багтдаг энэ салбарт 2016 оны эхний хагас жилийн байдлаар ойролцоогоор 20 мянга орчим орон сууц эзнээ хүлээж, 765 тэрбум төгрөг түгжигдээд байгаа юм. Ийм олон орон сууц эзнээ хүлээж байгаа гэсэн үг. Харамсалтай нь авах хүн байхгүй болчихсон. Дээрээс нь орон сууц борлогдоход хамгийн их нөлөөлж байсан ипотекийн зээлийн хурд саарчхлаа. Жилийн найман хувийн зээлээр орон сууц авах боломжтой, урьдчилгаагаа цуглуулчихсан, банкны шалгуурыг давах хүмүүс нь аль хэдийн орон сууцанд орчихсон. Жил ирэх тусам ипотекийн зээлд хамрагдаж, урьдчилгаа 30 хувиа

төлөөд, банкны шалгуураа даваад, хэт хөөрөгдчихсэн үнэтэй байр авах хүний тоо цөөрч байна. Ядаж байхад ярь гэжээр Монголбанкнаас саяхан ипотекийн таван хувийн зээлийг санхүүжүүлэх боломжгүйгэдгээ мэдэгдчихлээ. Мөн найман хувийн зээлд зарцуулах ёстой хөрөнгө мөнгийг арилжааны банкууд өөр зорилгоор ашигласан гэсэн гомдол гарсан учир түр зогсооход хүрээд байгаа аж. Улмаар төв банк шалгалтаа хийгээд явж байна, удахгүй үр дүн нь тодорхой болох байх. Засгийн газар болон БХБЯ-наас найман хувийн зээлийг ч олгоно. Таван хувийн зээлийг ч явуулна гэх маягийн юм яриад байгаа. Харин зээлийг санхүүжүүлэх эх үүсвэр нь хаана ч байгаа юм, бүү мэд. Улс орон хямарлаа, өрөө төлж дийлэхгүй нь, төсвөө чадах чинээгээр хасах

ёстой, бүсээ тултал чангалъя гэж байгаа энэ үед ипотекийн зээлийг санхүүжүүлэх хөрөнгө байх уу. Нөхцөл байдал нэг иймэрүү, хүндхэн л байна. Нөгөө талаар Засгийн газар ямар нэг арга олоод, таван хувийн зээлийг явууллаа гэж бодъё. Гэтэл арилжааны банкуудын хүнд шалгуурыг давж гарах хүн манайд хэд үлдсэн билээ. Өнөөдөр найман хувийн зээл хэвийн үргэлжилж байгаа гэдэг ч арилжааны банкууд өгч байгаа бил үү. Эдийн засаг хүндэрсэн гээд олгохоосоо олгохгүй нь их байгаа. Олгосон ч дааж давшгүй их шаардлага тавьж байгаа шүү дээ. Дээрээс нь эдийн засагчид болсон гэж зөвлөөд байгаа. Ийм байхад барилгын компаниуд, барилга захиралчид төрийг харж суухын хэрэг байна уу. Ёстой нөгөө “Бухын доодохыг

МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд

64

Аугаар

Захиалгын үнэ 18000

Монгол шуудан: 70078977
 ҮБ шуудан: 70121027
 Саяр пост: 70121294
 Түгээмэл шуудан: 70115025

ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.Баатарсүх:

...Урьдчилсан байдлаар, 230-аас дээш сая ам.долларын татварыг төвлөрүүлнэ гэж тооцож байна. Ойролцоогоор 600-700 хүн ажлын шинэ байраар хангагдана. Нүүрснээс байгалийн хий гаргаж авах төсөл гэхэд улсын төсөвт жилд 100 гаруй сая ам.долларыг төвлөрүүлдэг болох юм. Мөн 1000 орчим хүн ажлын байраар хангагдана. Зэс баяжуулах үйлдвэр татвараар жилд 12.8 сая ам.доллар улсын төсөвт төвлөрүүлж, 800-гаад ажлын байр бий болно гэсэн урьдчилсан төсөөлөл байна...

ХҮНД ҮЙЛДВЭРҮҮД АШИГЛАЛТАД ОРОХЫН ЦАГТ ААНДАА МӨНГИЙГ “ҮЙЛДВЭРЛЭЖ” ЭХЭЛНЭ

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Баатарсүхтэй ярилцлаа.

“Өмнөх Засгийн газар аж үйлдвэрийн салбарыг бодлогын хувьд бие даасан байх ёстой хэмээн үзэж, яам байгуулсан. Энэ удаад Уул уурхайн яам дэргэдээ авч явахар боллоо. Хоёр том салбарыг нэг бодлогоор авч явах нь хэр оновчтой шийдэл вэ. Үүнээс ярилцлагаа эхэлжэ?”

“Би асуултад тань хариулахаас өмнө хүнд үйлдвэр гэж юуг хэлэх талаархи эхний ойлголтыг өгөх нь зөв байх. Хүнд үйлдвэр гэдэг нь уул уурхайн салбарынхны олборлон баяжуулсан бүх бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явц гэж ойлгож болно. Хүнд үйлдвэрийн салбар онгоц болон хар төмөрлөгийн үйлдвэрүүд, дээрх нь машины үйлдвэрүүд, хэмийн хэсэгчилсэн бүлэг үйлдвэрүүд багтдаг. Үйлдвэрлэлийнх нь процесс хүнд, нарийн түвэгтэй учраас ийн нэрийдсэн хэрэг. Эдүгээ уул уурхай, хүнд үйлдвэрийн яам гэж нэрлээд уул уурхайн яам хүнд үйлдвэрийн салбараа хажуудаа бодлогоор авч явах болсон нь хамгийн зөв шийдэл болсон. Бүх зүйл гольдролдоо орсон гэж хэлж болно. Бодлогын хувьд ч асуудлыг цогцоор нь шийдэх боломж бүрдсэн. Тодруулж хэлбэл, геологи нь урьдчилсан хайгуулынхаа ажлыг хийж гүйцэтгэснийх нь дараа уул уурхайн хэлтэс баяжуулсаны эцэст хүнд үйлдвэрийн салбар анхан шатны боловсруулалт хийгдсэн түүхий эдийг бүрэн гүйцэт боловсруулж, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэх учиртай.”

“БНМАУ бас ч гэж хүнд үйлдвэрийн салбар хөгжих суурийг маш сайн тавьсан өгсөн гэж би хувьдаа боддог. Бодлого боловсруулагчдын хувьд бүх зүйлийг цоо шинээр харж эхлүүлээгүй л болов уу гэж санах юм. Та надтай санал нийлэх үү?”

“Хүнд үйлдвэрийн салбар гэж юу хэлэх талаар миний сая өгүүлсэн тодорхойлолтод нийцсэн үйлдвэрүүд гээд харахаар Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр, Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэртэй нэрлэж болно. Харамсалтай нь эдүгээ Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагаа нь

зогсох дээрээ тулаад байгаа. Бусдынх нь тухайд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүд шүү дээ. Арматур, зэс хайлуулах гэх мэтийн жижиг хэд хэдэн үйлдвэр бий, уг нь Хүнд үйлдвэрийн дотор нь металл ба металл бус гэж хоёр хуваадаг. Металл бус гэдэгт цементийн болоод барилгын материалын үйлдвэрүүд хамааралтай. Түүнчлэн газрын тос, нүүрс, химийн үйлдвэр нь металл буст хамрагдах учиртай гээд ойлгох хэрэгтэй. Монгол Улс газрын тос, нүүрс-химийн салбарт их хожуу хөл тавьж байгаа юм. Цоо шинэ салбар. Харин металлургийн салбарт бол бага зэрэг туршлагатай. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ашиглалтад ороод хэдэн жил болж байгаа билээ. Тэр хэрээр туршлага хуримтуулсан гэж хэлж болох байх. Зэс хайлуулах, баяжуулах чиглэлд уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг түшиглэсэн “Эрдмин”, “Ачит эх” гэх зэсний баяжмалаас катодын зэс гаргаж авдаг жижиг үйлдвэрүүд бий. Хар металлургын тухайд ч ялгаагүй Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрээ түшиглэдэг. Боловсон хүчний бааз суурийн хувьд ч боломжийн, Орхон аймагт гэхэд л Ш.Отгонбилэгийн нэрэмжит Техникийн их сургууль, Дарханы Техникийн их сургуульд тус тус мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэдэг. Тэгэхээр бид бүхнийг шинээр эхлүүлсэн бус хуучин байсан, бий болгосон бааз сууриа түшиглэж хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж байгаа хэрэг. Ер нь хүнд үйлдвэрийн салбарыг мөнгө үйлдвэрлэдэг машинтай дүйцүүлж болох юм.”

“Монгол Улс хүнд үйлдвэрийн салбарт ямар бодлого баримталж байна вэ?”

“Өмнөх Засгийн газар 2014 оны арванхоёрдугаар сард Аж үйлдвэрийн яамыг байгуулж, яам байгуулагдсангай холбогдуулан 2015 оны зургадугаар сарын 15 өдрийн УИХ-ын 62 дугаар тогтоолыг үндэслэн төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулсан байдаг. Түүнчлэн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс 2015 оны арваннэгдүгээр сард дунд хугацааны стратеги хөтөлбөрөө баталсан. Энэхүү стратеги хөтөлбөрт Монгол Улсыг үйлдвэржсэн орон болох талаархи бодлогыг нэлээн сайн тусгаж өгсөн байдаг. Тухайлбал, Монгол Улс зэсийн баяжмал хайлуулах үйлдвэртэй болохоор төлөвлөж, түүнийгээ ажил хэрэг болгон 2015 онд Хэнтийн Бор-Өндөрт зэсийн баяжмал хайгуулах

үйлдвэрийн суурийг тавьсан. Энэ нь шинэ цагийн Монгол Улс хүнд үйлдвэрийн салбарыг бодлогоор хөгжүүлэхийн эхлэл тавигдахын үндэс болсон гэж хэлж болно. Тэр ч утгаараа шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх, үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцлийг бүрдүүлнэ, Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах гээд заасан байгаа. Оюутолгой, Цагаан суварга, Эрдэнэт үйлдвэрээ түшиглээд зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр барь. Эхний ээлжинд жилд 520 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 120 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр барихаар төлөвлөсөн. Нөгөөтэйгүүр, Монгол Улс дотоодын хэрэгцээгээ хангаад байхуйц газрын тосны баялаг нөөцтэй. Газрын тосны олборлолт жилээс жилд нэмэгдэж, жилдээ 1.5 сая тонн газрын тос олборлодог болсон. Үүнийгээ ашиглаад газрын тос боловсруулах үйлдвэр барьж, ашиглалтад оруулах бодлого баримталж буй. Дээрээс нь манайх нүүрсний асар их нөөцтэй орон. Нүүрсээ хийжүүлээд нийлэг хий гэж нэрлэж байгаа сентитик газ үйлдвэрлэн утаанаасаа бүрэн ангижрах боломжтой. Үр дүн нь юу гэхээр Монгол Улс нэгдүгээрт, хүнд үйлдвэртэй, хоёрдугаарт, байгаль орчинд таатай аюулгүй орон болох юм. Ирэх дөрвөн жилд багтааж дээрх үйлдвэрүүдийг барихаар төлөвлөсөн. Дээр нь хар төмөрлөгийнхөө үйлдвэрийг түшиглээд Дархан, Сэлэнгийн бүсэд төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулахаар болж, бэлтгэл ажилдаа орцгоосон. Тэгэхээр хар металлургийн чиглэлд том цогцолбор үйлдвэртэй, онгоц металлургийн чиглэлд зэсийн үйлдвэртэй, газрын тос боловсруулах чиглэлдээ газрын тосны үйлдвэртэй, нүүрс-химийн чиглэлд нүүрснээс хий гаргаж авах ийм цогцолбор бүхий үйлдвэрүүдийг барьж, хүнд үйлдвэрийн салбарыг ойрын үед эдийн засгийн эргэлтэд оруулна гэж ойлгож болно.”

“Үнэнийг хэлэхэд, манайх

хүнд үйлдвэр барих нь бүү хэл, эдийн засгийн чадавхитай улс. Тиймээс гадны хөрөнгө оруулагчдыг найр тавьж утгах биз. Тэдэнд үзүүлэх ТЭЗҮ нь бий юу. Одоогийн байдлаар аль нэг үйлдвэрт хөрөнгө оруулах хүсэлтээ ирүүлсэн орон, компани байна уу?”

“Миний сая дурдсан үйлдвэрүүдийн ТЭЗҮ урьдчилсан байдлаар боловсруулагдсан байгаа. Урьдчилсан гэдэг нь манай улсын Засгийн газрын захиалгаар, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн төслүүд юм. Мөн дуусаагүй төслүүд ч бий. Урьдчилсан байдлаар хийгдсэн ТЭЗҮ-г үндэслэж, техникийнхээ даалгаврыг хийлгээд цааш үргэлжлүүлээд үйлдвэрүүдээ барьж, ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй. Хөрөнгө оруулагчийг татах тухайд Монгол Улс байршлаа сонгоод төндрээ зарлаад эхлэх үед хөрөнгө оруулалтаа хийгээд хамтарсан эсвэл дангаараа эзэмшээд явах боломж, бололцоо бүрдэнэ гэж ойлгож болно.”

“Хүнд үйлдвэрийн салбарыг сонирхох гадны хөрөнгө оруулагчид юун түрүүнд хууль, эрхзүйн орчин нь хэр боловсронгуй юм, бодлого нь тогтвортой байж чадаж байна уу гэдгийг л судлах байх?”

“Бид гадны хөрөнгө оруулагчдыг урин дуудах, татах чиглэлээр нэлээд зүйлийг санаж, сэдэж ажиллах учиртай. Ажиллаж ч байна. Саяхан болж өнгөрсөн уул уурхайн салбарын чуулга уулзалт дээр гадны хөрөнгө оруулагчид Монгол Улсын уул уурхайн салбарын хууль, эрх зүйн орчин харьцангуй сайжирсан хэмээн дүгнэж байна лээ. Шинэ Засгийн газраас гэхэд л 20 тэрбумаас дээш хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчийг гаалийн татвараас хөнгөлөх гэхчилэн татварын таатай нөхцлийг санал болгож буй.”

“Эхний үйлдвэр хэзээ ашиглалтад орохоор төлөвлөж байгаа вэ. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гаргах зах зээлээ хэчнээн орноор төсөөлж байгаа бол?”

“Юун түрүүнд байгаа нөөц боломжоо ашиглаад газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрээ барихаар төлөвлөж байгаа. Түүхий эд нь ч манайд хангалттай. Боловсруулах үйлдвэртэй болж гэмэнэнэ дотоодын зах зээлээ бүрэн хангах бололцоотой. Төслийн гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу явбал 2-2.5 жилд багтан үйлдвэр ашиглалтад

орж, 2020 оноос газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангах нөхцөл бүрдэнэ. Дашрамд өгүүлэхэд, Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглэндээ жилд 1.5 тэрбум ам.доллар зарцуулж, тэр их мөнгө дандаа гадагшаа урссан байдаг. Тэгэхээр импортыг зогсоож, гадагшаа урсдаг валют дотооддоо эргэлдэхээр эдийн засагт сайнаар нөлөөлөх нь ойлгомжтой. Зэс хайлуулах үйлдвэрийн хувьд ойролцоогоор дөрвөн жилийн хугацаанд баригдана. ТЭЗҮ-ийг нь боловсруулахдаа уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн түшиглэсэн агаад “Эрдэнэт” үйлдвэр өөрсдөө ажлын даалгаврыг нь өгсөн юм билээ. Үүний дагуу ТЭЗҮ нь боловсруулагдсан. Үйлдвэр ашиглалтад ормоц л катодын зэс үйлдвэрлэж, олон улсын зах зээлд гаргана гэсэн үг. Нүүрсний хувьд түрүүнхэлсэн члэн нүүрсээ хийжүүлээд, хийжүүлсэн нүүрсээ эхний ээлжинд дотооддоо хэрэглэнэ. Энэ их утааг байхгүй болгоно. Энэ нь макро түвшиндээ ч, эдийн засгийн хувьд ч ашигтай шүү дээ. Ийм төслүүд байна. Хар төмөрлөгийн үйлдвэр бүрэн утгаараа ажиллаж эхэлснээр жилд 500 мянган тонн ангижруулсан төмөр, 300 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм. Энэ төсөл хэрэгжээд эхлэхээр мөн л дотоодынхоо зах зээлийг эхний ээлжинд хангана гэсэн зорилготой.”

“Хүнд үйлдвэрийн салбарт боловсон хүчний хангамж хүрэлцээ ямар байдаг вэ?”

“Боловсон хүчний хувьд тааруу, нарийн мэргэшсэн мэргэжилтнүүд цөөхөн. Үйлдвэрүүд баригдаж байх явцад боловсон хүчнээ сургаж авна гэсэн зорилго тавьж байгаа. Ажлын байруудыг шинээр бий болгоно. Боловсон хүчнээ сургаж авна. Энэ бүх асуудлуудыг цогцоор нь шийднэ гэж ойлгож болно.”

“Хүнд үйлдвэрүүд ашиглалтад орохын цагт Монгол Улсын эдийн засаг ингэж сэргэнэ гэсэн төсөөлөл бий л байх, ТЭЗҮ-д. Зөвхөн тойм тоон үзүүлэлтээсээ дурдвал?”

“Хүнд үйлдвэрлэл өөрөө асар их хэмжээний хөрөнгө шаардаж байж хөл дээрээ босдог салбар. Тэр хэрээр хөрөнгө оруулалтаа нөхөх ажил нь нэлээд урт хугацаанд үргэлжилдэг онцлогтой. Бидний төсөөлж харж буйгаар бол газрын тос боловсруулах үйлдвэр эхлээд улсын эдийн засагт ашиг тусгаа өгөх учиртай. Урьдчилсан байдлаар, 230-аас

дээш сая ам.долларын татварыг төвлөрүүлнэ гэж тооцож байна. Ойролцоогоор 600-700 хүн ажлын шинэ байраар хангагдана. Нүүрснээс байгалийн хий гаргаж авах төсөл гэхэд улсын төсөвт жилд 100 гаруй сая ам.долларыг төвлөрүүлдэг болох юм. Мөн 1000 орчим хүн ажлын байраар хангагдана. Зэс баяжуулах үйлдвэр татвараар жилд 12.8 сая ам.доллар улсын төсөвт төвлөрүүлж, 800-гаад ажлын байр бий болно гэсэн урьдчилсан төсөөлөл байна. Энэ бүхэн зөвхөн төсөөлөл гэдгийг ойлгоорой.”

“Сөрөг асуулт байж мэднэ. Бидний мөнхийн хоёр хөрш маань дэлхийн хүнд үйлдвэрийн акулуд. Тиймээс тэдний дунд орших Монгол Улсад хүнд үйлдвэрийн салбарыг дэлхийтэй өрсөлдөхүйц хэмжээнд хөгжүүлэх шаардлага байгаа юм уу. Зах зээлээ яаж тодорхойлж байгаа юм бол. Эсвэл манай түүхий эдийн чанар хоёр хөршөөс илүү юм уу?”

“Гуравдагч зах зээлийн хувьд хүндрэлтэй зүйл бий. Яагаад гэхээр бид чинь дэд бүтцээ ч сайн барьж байгуулж чадаагүй байгаа шүү дээ. Цашид энэ чигээрээ урсаад байж болохгүй. Төмөр замын асуудлуудаа ойрын үед шийдэнэ. Төмөр замтай болсноор бүтээгдэхүүнээ далайн боомтойд хүргэх цаашлаад гуравдагч зах зээл рүү хөл тавих нөхцөл бүрдэнэ. Хоёр аварга том гүрний дунд оршдог юм чинь гээд тэдний түүхий эдийн бааз маягаар явна гэвэл өрсөсгөл ойлголт. Тиймээс өөрсдийнхөө олборлосон түүхийг бүтээгдэхүүнээ дээр өгүүлсэн члэн хүнд үйлдвэр гэх мөнгөний машинаа ажилд оруулаад эхэлбэл, олон зүйлд санаа зовохгүй болно. Өнөөг хүртэл Монгол Улс цаг үргэлж түүхий эд бэлтгэдэг орон байлаа шүү дээ. Ийм байж таарахгүй. Ялангуяа, хар болон онгоц төмөрлөгийн үйлдвэрлэл цаашлаад полиметаллын чиглэлд боловсруулах үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах нь зүйтэй. Мөн стратегийн бүтээгдэхүүн болох газрын тос боловсруулах үйлдвэрээ зайшгүй дотооддоо боловсруулах шаардлага тулгарч буй. Түүнчлэн ард түмэн, байгаль орчноо бодоод ч тэр түүхий нүүрс шатаадаг тэр байдлаасаа салж, хийн түлшнийг ахуйдаа ашиглаж сурах цаг болсон. Тэр утгаараа нүүрс, химийн үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах ажлыг төр бодлогоор дэмжиж ирсэн.”



MMINFO.

Тал нутгийн цахим мэдээлэл

ОНЦЛОХ ХУУДАС

МАНдуулах ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАГДЧИХЛАА ХАРИН ОДОО...

Эсрэг тэсрэг байр суурь

Д.Хаянхярваа: Мөрийн хөтөлбөрийг ном дүрмийн дагуу хийсэн



/МАН-ын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн/

“Өнөөдрийн эдийн засаг юун мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй мантай байна. Мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлнэ гэж хэлэхэд бэрх эдийн засагтай болчихоод байгаа. Мөнгө, хөрөнгө, санхүү өнөөдөр бидний тооцоолж байснаас үнэхээр доогуур байна. Ганцхан жишээ хэлэхэд, АН-ынхан өнгөрсөн 6-7 дугаар сард гэхэд нэг их наяд гаруй төгрөгийг хууль бусаар зарчихсан. Тэр нь өнөөдөр төсөв дээр ачаа болоод сууж байна. Төсвийн алдагдал их байгаа. Бид ирэх жил зөвхөн төсвийн алдагдлаа нөхөж, зээлийн төлбөрөө өгөхөд төсөв хүрэхгүй болчихоод байна. Ийм байдалтай байгаа гэхэд харин ч бид сайжруулна, болгоно, хийнэ гээд бүх зүйлийг мөрийн хөтөлбөрт тусгаж өгсөн. Мөрийн хөтөлбөрөө МАН хэрэгжүүлнэ. 2016, 2017, 2018 онд жаахан хүнд жилүүд байж магадгүй. Тиймээс мөрийн хөтөлбөрийн хэрэгжих заалтууд хугацааны хувьд зарим нэг нь хойшоо шахагдах асуудал гарахыг бид үгүйсгэхгүй. Яагаад гэвэл эхний ээлжинд унаж, доройтчихсон байгаа эдийн засгаа жаахан тогтворжуулж хэрэгтэй. Уналтаа зогсоож, эдийн засгийн боломжтой болмоор байна. Агуулгын хувьд бүх зүйл Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдчихсан.”

...эхний ээлжинд унаж, доройтчихсон байгаа эдийн засгаа жаахан тогтворжуулж хэрэгтэй. Уналтаа зогсоож, эдийн засгийн боломжтой болмоор байна. Агуулгын хувьд бүх зүйл Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдчихсан...

...С вирусны голомтыг устгана гээд цагаан дээр хараар бичсэн заалт, малчны зээлийн хүүг буруулна, гэр хорооллын дэд бүтцийн асуудал, түрээсийн орон сууцны бодлогыг үргэлжлүүлнэ гэх зэрэг заалтууд байхгүй болчихоод байгаа...



Л.Болд: Мөрийн хөтөлбөрт иргэдийн саналыг ихээр авсан заалтууд орохгүй

/УИХ-ын гишүүн/

“МАН-ынхан мөрийн хөтөлбөрөө ард түмэн ярьж, таниулж, ухуулан ард түмний саналыг авсан. Тиймээс ч өнөөдөр төрийн өндөрлөгт суусан гэж ойлгож байгаа. Дараагийн дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлбарт эхний хоёр жил жаахан хүнд байна. Учир нь өмнөх Засгийн газрын үед хүндэрчхсэн гэсэн байгаа. Сүүлийн хоёр жил сайхан болно гэх. Гэтэл мөрийн хөтөлбөрт сайн, муу бүх зүйлээ багтаагаад л хэрэгжүүлэх ёстой гэж ойлгоод байгаа. Харин энэ удаагийн хөтөлбөрт МАН-ын мөрийн хөтөлбөр бүрэн туссан юм уу гэхээр 90 хувийг тусгасан байгаа. Харин 10 хувь нь шаардлагагүй гэж үзсэн гэдэг хариуг эрх баригчид өгөөд байгаа. Тэгэхээр нь үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг харьцуулаад үзэхээр 10 хувьд нь маш чухал заалтууд нь үлдчихсэн байна. Тодруулбал, боловсролын зээлийн сан буюу оюутны зээлийн асуудал, хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт олгох, цалинтай ээж, тэтгэвэр тэтгэмжийг нэмэх асуудал, тэтгэвэрийн зээлийн хүүг бууруулах, орлого багатай иргэдийг дэмжих зэрэг иргэдийн саналыг ихээр авсан заалтууд орохгүй байна. Түүнчлэн С вирусны голомтыг устгана гээд цагаан дээр хараар бичсэн заалт, малчны зээлийн хүүг буруулна, гэр хорооллын дэд бүтцийн асуудал, түрээсийн орон сууцны бодлогыг үргэлжлүүлнэ гэх зэрэг заалтууд байхгүй болчихоод байгаа. Эдгээр тусгагддаггүй байна гээд асуухаар ямар нэгэн хэлбэрээр орчихсон гэж бүх амлалтаа унагаагаад байна. Ингэж амлалтаа унагаад байгаа нь ард иргэдээ хуурсан явдал. Намын мөрийн хөтөлбөрт “Оюутан бүрийг хамруулах” тухай байгаа бол Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “дэмжинэ, өргөжүүлнэ, нэмэгдүүлнэ” гэх зэрэг ялгаварласан зүйл батлагдчихлаа. Энэ мэт сул үйл үгээр амлалтаасаа буцаж байна.”

Сэтгүүлчийн дүгнэлт “РОМАНТИК” ХӨТӨЛБӨРҮҮД АМЬДРАЛД БУУХ НЬ

Ж.МЯГМАР

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаад байгаа. Сөрөг хүчний зүгээс МАН-ын амлалтуудыг мөрийн хөтөлбөрт тусгагдсан томъёоллоор нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгуулахаар нэлээд хүчин чармайлт гаргасан ч бүтэлгүйтсэн юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Л.Болд “МАН-ын мөрийн хөтөлбөрт туссан оюутан бүрийг тэтгэлэгт хамруулах заалт нь Засгийн газрын энэ хөтөлбөрт зааснаас илүү сайн томъёоллолттой байгаа юм. Үүнийг та бүхэн дэмжвэл Оюутны холбооны ерөнхийлөгч байсан хүний хувьд баярлах байна” хэмээн санал гаргасныхаа дараа залуу гишүүн Н.Цэрэнбатад хатуу зэмлүүлээд авсан юм. УИХ-ын залуу гишүүн Н.Цэрэнбат “Та үсээ цайтал Монголын төрд зүтгэсэн, тулхтай түшээ мөн. Та Монголын Оюутны холбоог өдий зэрэгтэй явахад гар оролцсон хүний хувьд ингэж ярьж болохгүй ээ. Таны хэлээд буй зүйлс Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд орно.”

Та туршлагатай, ахмад, буурал түшээ хүний хувьд микрофон харахаараа ингэж болохгүй шүү” хэмээн чуулганы танхим зандрал авсан. Угтаа бол МАН-ын мөрийн хөтөлбөрт багтсан “халамжийн” шинжтэй хэд хэдэн заалтуудын нэг болох “оюутан бүрийг сургалтын зээлд хамруулах” тухай заасан байдаг. Харин Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “дэмжинэ, өргөжүүлнэ, нэмэгдүүлнэ” гэх зэрэг ялгаварласан зүйл батлагдчихлаа гэдгийг хэлсэнийхээ төлөө Л.Болд гишүүн УИХ-ын залуу гишүүнд буурал үстэй, ахмад хүн байж аятайхан бай хэмээн “загнуулаад” авсан. Түүнчлэн хүүхдийн мөнгийг 60 хувьд олоно, 40 хувьд яваандаа олгох, цалинтай ээж, эрчим хүчний үнийг бууруулах, залуусыг орон сууцаар хангах хөтөлбөр зэрэг олон асуудал хурцаар яригдсан ч тусыг эс олж, гишүүд олонхоороо хүч түрэн Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө батлаад авлаа. Гэхдээ өрийн таазыг нэмэгдүүлэн, зээл авч, бүтээн байгуулалтыг зогсоож, “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдан, эдийн засгаа “нүдээ бүлгнэ” чангалуулсан хатуухан он жилүүд монголчуудыг утгаж байгаа бололтой. Тиймээс “халамжийн” шинжтэй зарим амлалтуудаасаа татгалзсан нь зөв ч байж болох юм.

Тэгээд ч энэ удаагийн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг төсөвтэйгөө уялдаж чадаагүй гэдгийг мэдэх хүмүүс хэлж буй. Гэсэн хэдий ч эрх баригчид сонгуулийн үеэр амласан учир хэрэгжих эсэх нь тодорхойгүй амлалтуудаа мөрийн хөтөлбөртөө багтаасан. УИХ-ын гишүүн Ж.Батзандангийн хэлсэнчлэн “Насны хишиг”, “Ач санах”, “Нутгийн зон”, “Жаргалтай ээж” гээд романтик хөтөлбөрүүд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдчихлаа. Тиймээс одоо хэрэгжих эсэхийг л хүлээх үлдлээ. Юутай чсөрөг хүчний хувьд МАН-ынхан Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө чухал заалтуудаа тусгаж чадаагүй, сонгогчдыг хуурсан хэмээн дүгнэж буй. Харин эрх баригчдын зүгээс эдийн засаг хямралтай энэ жилүүдэд харин ч мөрийн хөтөлбөртөө хэрэгжиж болох бүх амлалтуудаа боломжийн хэмжээнд тусгаад өгчихсэн хэмээн дүгнэлээ.

Б.Пүрэвдорж: Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг дэндүү бөөрөнхий байна

/УИХ-ын гишүүн/

“2016 оны сонгуулийн МАН-ын мөрийн хөтөлбөр гайхамшигтай сайхан байсан. Бүх ард түмэнд буюу бүх төвшинд асуудлыг нь шийдэхээр АН-ын хэрэгжүүлж байсан зүйлүүдийг илүү давуулан биелүүлэхээр байсан. Гэтэл Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг харж байхад дэндүү бөөрөнхий байна. Дэмжиж ажиллана, зүтгэх болно гэсэн байдлаар тусгаж байгаад бид харамсаж байна. АН 2012 онд Засаг авахдаа хоёр тэрбумын зээлтэй хүлээн авч байсан. Тэглээ гээд АН арагшаа харж улстөржөөгүй. Гэтэл энэ удаагийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ямар ч эдийн засгийн бодлого алга.”

Л.Энх-Амгалан: Ирэх дөрвөн жилд зорилтуудаа хэрэгжүүлнэ

/УИХ-ын гишүүн/

“Бид хүн амынхаа бүх давхаргад хүрсэн бодлого явуулахаа амласан. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн цэцэрлэгийн хангамжийг ирэх дөрвөн жилд шийдвэрлэх, хүүхдүүдийн сурах орчин, сурах бичгийн хүрэлцээ, багш нарын чадварыг дээшлүүлэх зорилтуудыг тавьсан. Мөн их, дээд сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах, оюутан нь өөрөө боловсролынхоо зээлийг авч, зээлээ өөрөө төлдөг байх, төгсөгчдийг ажлын байраар хангах, ахмадуудын тэтгэвэр тэтгэмж нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг байх, нийт иргэдээ жил бүр эмчилгээ оношлогоонд хамруулах гээд том зорилтууд бий. Энэ зорилтуудаа Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөр болгож баталлаа. Засгийн газар мөрийн хөтөлбөр болгоод баталчихсан учраас бид ирэх дөрвөн жилд зорилтуудаа хэрэгжүүлнэ. Гэхдээ энэ мөрийн хөтөлбөрийг хоёр үе шаттай хэрэгжүүлнэ. Яагаад гэвэл өнөөдрийн нийгэм, эдийн засагт үүссэн хүндрэл, бэрхшээлийг бид 2018 оны дунд үе хүртэл хугацаанд давж гаръя. Эхний хоёр жилд бид уналтаас гаръя. Тэгээд 2018 оноос 2020 он хүртэл бид нийгмийн салбарт амласан амлалтуудаа биелүүлнэ. Хамгийн чухал нь бид намынхаа сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Засгийн газрын мөрийн хөтөлбөр болгоод авч байгаа нь чухал алхам. Сонгуулиар амлаж байсан бүх амлалтууд биелэх шатандаа орж байна. Малчдын тэтгэврийн насыг таван жилээр наашлуулах, малчдын тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, эрүүл мэнд тусламж үйлчилгээний хүрэлцээ, чанарыг шинэ шатанд гаргах эдгээр зорилтуудаа УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны хувьд хэрэгжүүлээд явна. Ирэх саруудад малчны тэтгэврийн зээлийн хүүг бодитоор бууруулах боломж харагдаж байна. Мөн 1072 ширхэг хувьцааны асуудлыг шийднэ. Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ирээдүйд иргэд маань хувьцааныхаа үнэ цэнийг хүртэх гээд хийж хэрэгжүүлэх ажил олон байна. Хүүхдийн мөнгийг үндсэндээ 60 хувь хасчихлаа гэж шүүмжилж байна. Хасаагүй. Яг өнөөдөр хүүхдийн мөнгө шаардлагатай 60 хувьд нь өгье. Үлдсэн 40 хувьд нь хуримтлал үүсгээд 2019 оноос өгөх боломжтой болно гэсэн үг.”

ДЭЛХИЙ

Танзанид газар хөдөллөө

Африкийн Танзани улсын баруун хойд хэсэгт өнгөрөгч бямба гарагийн 15.27 цагт 5.7 магнитудын хүчтэй газар хөдөлсний улмаас 16 хүн нас барж, 253 хүн хүнд, хөнгөн гэмтжээ. Газар хөдөллийн голомт Викториа нууртай залгаа орших баруун хойд тэгээдийн Нсунгагаас зүүн тийш 25 км-т байсан бөгөөд гүн 40 км-т байсан аж. АНУ-ын геологийн судалгааны хүрээлэнгээс мэдээлснээр газар хөдөллийн чичиргээн тус улстай хиллэдэг Руанда, Бурунди, Уганда, Кени зэрэг улсад мэдрэгдсэн байна. Газар хөдөллийн голомттой ойролцоо Букобагийн бүс нутаг хамгийн их хохирол амссан бөгөөд 800 гаруй байшин барилга нуржээ. Угандад ч гэсэн олон тооны байшин барилга эвдэрч сүйдсэн гэдгийг албаны эх сурвалж онцолсон байна. Гэхдээ Букобагаас 1400 орчим км-т орших Танзани улсын нийслэл Дар ес Салаамд одоогоор ямар нэг хохирлын талаарх мэдээлэл бүртгэгдээгүй байгаа ажээ.

Эрдоган орон нутгийн удирдлагуудаа ажлаас нь чөлөөлж эхэллээ

Туркийн Засгийн газар өнгөрсөн долдугаар сарын 15-ны өдөр зарим цэргийнхний төрийн эргэлт хийх оролдлоготой холбогдуулан олон мянган хүнийг баривчлан саатуулснаас гадна төрийн алба хаагчдыг олноор нь ажлаас нь халаад буй. Тэд АНУ-д орогнож буй лалын шашны бүлэглэлийн тэргүүн Фетуллах Гюленг тус эргэлтийг хөшигний араас удирдсан хэмээн хардаж байгаа юм. Тэгвэл тус улсын Засгийн газар мөн хэрэгт холбогдуулан Курдын эвсэгт босогчид болон Фетуллах Гюлентай холбоотой гэх үндэслэлээр орон нутгийн засаг захиргааны 28 удирдлагаа ажлаас нь халж, оронд нь өөр хүмүүсийг шинээр томилжээ. Албан тушаалаасаа огцорсон орон нутгийн удирдлагууд ихэвчлэн курдууд хүн амын олонхийг эзлэх засаг захиргааны нэгжийн засаг дарга нар байжээ. Тодруулбал, Диярбакыр хотын Сур дүүрэг, Силван, Мардин, Нусайбин зэрэг гол гол хот, дүүргийн засаг дарга нар үүнд багтсан байна. Туркийн Дотоод хэргийн яамны мэдээгдэлд дурьдсанаар, ажлаасаа халагдсан 28 албан тушаалтны 24 нь Курдын босогчидтой холбоотой нь нотлогдсон бол дөрөв нь цэргийн эргэлтийг удирдсан Гюлены хамсаатнууд байсан гэнэ. Гэхдээ АНУ-д орогнож буй шашин судлаач Гюлен уг хэргийг үгүйсгэж байгаа юм.



СОЛОНГОСЫН ХОЙГ “ДАЙНЫ БЭЛЭН БАЙДАЛ”-Д ШИЛЖЛЭЭ

Б.ДАВААХҮҮ

БНАСАУ өнгөрсөн долоо хоногт тав дахь цөмийн зэвсгээ туршсан. Орон нутгийн эх сурвалжийн мэдэгдсэнээр энэ туршилтаар Пхеньяны цөмийн мэргэжилтнүүд баллистик пуужинд тохирох цөмийн хошууг бий болгож чадсан гэх. Тэгвэл эдүгээ дахин цөмийн зэвсэг туршихаар бэлтгэлээ базааж буйг АНУ, БНСУ-ын тагнуулынхан олж мэдсэнээр солонгосын хойгийн байдал түгшүүртэй болж эхэллээ. БНСУ-ын Батлан хамгаалах яамнаас өчигдөр хэвлэлийн хурал зарлаж, солонгосын хойгийн байдал урьд өмнө нь байгаагүй хамгийн муу төвшинд хүрснийг онцолжээ. Пхеньян тав дахь удаагийн цөмийн зэвсгээ туршсантай холбогдуулан Сөүл онц байдал зарлаж, ажиглалтаа чангатгаж БНАСАУ-ын цөмийн мэргэжилтнүүдийн алхам бүрийг хянаж байгаа юм.

Өнгөрсөн баасан гарагт Ким цөмийн зэвсгээ туршсаны дараа БНСУ-ын Батлан хамгаалахын сайд парламентын хуралдаан дээр “Энэ удаа

цөмийн зэвсэг туршсан талбайгаас өөр талбайд тэд бэлтгэл базааж байгааг үнэлж мэдэгдсэн юм. Тэрбээр мөн БНАСАУ-ын зүүн хойд этгээд дэх Умар Хамгён аймгийн Пункёри гэх газар дахь талбайд шинээр цөмийн зэвсэг туршихаар бэлтгэлээ базааж байгаа тухай дурьдаж, анхааруулжээ. Тэгвэл өчигдөр тус яамны төлөөлөгч Мүн Сан Гюн салбарын сайдын хэлсэн үгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэлийнхэнд өгсөн байна. Тодруулбал, Хойд Солонгос хамгийн анхны цөмийн зэвсгийн туршилтаа нэгдүгээр тунельд гүйцэтгэсэн бол 2-5 дахь туршилтыг хоёр дахь тунельд туршчээ. Харин эдүгээ хоёр дахь тунелийн ойролцоо буюу өөр талбайд цөмийн туршилт хийхээр

бэлтгэж байгаа аж. Иймээс Өмнөд Солонгосын цэргийнхэн Пхеньяны цөмийн зэвсэг ашиглан түрэмгийлж болзошгүй аюулаас сэрэмжлэн бүх бэлтгэлийг ханган дайны бэлэн байдалд шилжиж, ажиглалтаа чангатгажээ.

Гэхдээ хамгийн ноцтой нь БНСУ-ын Батлан хамгаалах яам Пхеньяны цөмийн зэвсэг туршсаныг эсэргүүцэн хариуг нь барих зорилгоор ирэх сарын 10-наас эхлэн зургаан өдрийн хугацаанд Солонгосын хойгийн шар тэнгист цэргийн сургуулилт хийхээр болсон явдал байв. Солонгосын хойгт үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэхдээ цэргийн албаны эх сурвалж энэ талаар онцолсон байна. Энэхүү цэргийн сургуулилыг АНУ, БНСУ-ын тал хамран зохион байгуулах бөгөөд АНУ-ын талаас нисэх онгоц тээвэрлэгчүүд ч мөн оролдох ажээ. Түүнчлэн, ойрын хугацаанд АНУ-ын стратегийн бөмбөгдөгч онгоц Солонгосын хойг тийш хөдөлнө гэдгийг албаныхан онцолжээ. Өнгөрсөн наймдугаар сард Солонгосын хойгт АНУ, БНСУ-ын түүхэнд байгаагүй томоохон хамтарсан цэргийн сургуулилт зохион

байгуулагдаж байсан бөгөөд энэ үед Пхеньяны зүгээс “АНУ цэргийн өдөөн хатгалга” явуулж байгааг онцлон даруй зогсоохыг сануулж байсан. Түүний дараа Японы тэнгисийн зүг баллистик пуужин харваж анхааруулга өгч байсан билээ.

Хоёр Солонгосын байдал хурцдсан энэ үед АНУ дахин БНСУ-тай хамтарсан цэргийн сургуулилт хийснээр хойгт урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсч болзошгүй байна. Үүнээс гадна Пхеньян дараагийн туршилтаа хэзээ хийх, тус зэвсэг нь хэр хор хөнөөлтэй болох нь БНСУ төдийгүй, бүс нутгийнхныг айдас автуулж байгаа юм. Нөгөө талаар, өнөөдрөөс НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хуралдаан эхэлнэ. Энэ хуралд БНАСАУ-ын Гадаад хэргийн сайд оролцох бөгөөд тэрбээр хуралдаан дээр улсаа төлөөлөн тайлбар хийх аж. Зарим ажиглагчдын таамаглаж буйгаар Ли сайд Пхеньяны цөмийн туршилт “АНУ-ын цөмийн аюулын эсрэг арга хэмжээ” хэмээн онцолж, цөмийн туршилтаа зөвтгөхөөс гадна цөмийн зэвсгийн хөгжүүлэлтийн талаар мэдээлэх гэнэ.

Хиллари Клинтон уушигны хатгалгаа тусчээ



АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшиж буй Хиллари Клинтон уушигны хатгалгаа тусчээ. Тэрбээр Нью-Йорк хотод зохион байгуулагдсан 2001 оны есдүгээр сарын 11-ний терроризмын гашуудлын ёслолд оролцсон хэдий ч, бие нь муудсаны улмаас дуусгаж чадалгүй гэртээ харьсан байна. Тэгвэл түүнийг эмчлэгч эмч нь хэд хоногийн өмнө түүнийг уушигны хатгалгаа туссан гэж оношлогдсон талаар хэвлэлийнхэнд ярьжээ. Түүнчлэн, одоогоор биений байдал нь өмнөхөөсөө дээрдэж буйг онцолсон байна. АНУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль болоход ердөө найман долоо хоногийн хугацаа үлдээд буй. Гэвч түүний биений байдал олны анхаарлыг татаж эхэллээ. Клинтон сурталчилгааны албанаас мэдээлж буйгаар терроризмын гашуудлын ёслолд тэрбээр 90 минут саатсаны эцэст гэртээ харьсан гэнэ. Түүнчлэн, Калифорни мужид болох сонгуулийн уулзалтаа ч эрүүл мэндийн байдлаас үүдэлтэйгээ цуцалсан гэдгийг түүний төлөөлөгч онцолсон байв.


Үерийн улмаас нас барагсдын тоо 133 болжээ

АНУ, БНСУ тэргүүтэй орнууд Пхеньяны цөмийн зэвсэг туршихаар бэлтгэж буй хэмээн хардаж байх зуурт тус улсын зүүн хойд хэсэгт үер бууж, олон хүний амь эрсдэйд байна. НҮБ-аас гаргасан тоон мэдээллээр өчигдрийг хүртэл тухайн бүс нутагт үерийн улмаас нас барагсдын тоо 133 болон нэмэгдэж, 395 хүн ор сураггүй болсонд тооцогдох болжээ. Хойд Солонгост хэдэн өдрийн турш хур тунадас их хэмжээгээр орсны улмаас үер бууж, түмэн гэх голын орчмын бүс нутаг дахь 107 мянга орчим хүн ор гэрээсээ дайжихаас өөр аргагүй болжээ. Түүнчлэн, 35500 байшин барилга эвдэрч гэмтсэнээс 69 хувь нь бүр мөсөн нурсан байна. Мөн нийтийн 8700 байшин эвдэрч сүйджээ. Үерийн гамшиг хөдөө аж ахуйн 1600 га газрын хамарсан байх бөгөөд хамгийн багадаа 140 мянган хүнд яаралтай тусламж шаардлагатай байгаа гэнэ.



ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ





MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...




ШУУРХАЙ МЭДЭЭ

БАНКНЫ КАРТНЫ ЗАЛИЛАНГИЙН 480 ХЭРЭГ БҮРТГЭГДСЭН

Н.БАТЗАЯА

Улаанбаатар хотын цагдаагийн газраас очигдөр сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Энэ үеэр ЦЕГ-ын Хөвлөл мэдээллийн төвийн дарга, цагдаагийн хошууч Б.Баатархүүгээс зарим зүйлийг тодрууллаа.

-Сүүлийн үед монгол иргэдийн данснаас мөнгө алдагдах, хууль бус гүйлгээ хийгдэх болсон. Энэ талын гэмт хэрэг хэр бүртгэгдэж байна вэ?

-Урьд нь гадаад улсын иргэдийн цахим картан дахь мэдээллийг хууль бусаар олж аван төлбөрийн тооцоо хийсэн хэрэг хэд хэдэн удаа гарч байсан. Тэгвэл сүүлийн үед цагдаагийн байгууллагад Монгол Улсын иргэдийн банкны картан дахь төлбөрийн мэдээллийг хууль бусаар олж авч, гадаадад гүйлгээ хийсэн хэрэг бүртгэгдэх болсон. Энэ төрлийн гэмт хэргийн дуудлага цагдаагийн байгууллагад ирж байна. Одоогийн байдлаар банкны картны залилангийн гэмт хэрэгт өртсөн, хохирогч болсон 480 гаруй иргэний хэргийг Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс шалгаж байна.

-480 хэрэг бүртгэгдсэн гэлээ. Эдгээр иргэд нийт хэчнээн төгрөг картнаасаа алдсан бэ?

-480 иргэн 120 сая орчим

...480 иргэн 120 сая орчим төгрөгөөр хохирсон. Тэгэхээр иргэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Тухайлбал, цахим картаа хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нэн яаралтай хаалгах, өөрийн итгэлгүй хүндээ картаа өгөх, хувийн мэдээлэл нууц дугаараа хэлж өгөхгүй байх шаардлагатай...

төгрөгөөр хохирсон. Тэгэхээр иргэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Тухайлбал, цахим картаа хаяж

үрэгдүүлсэн тохиолдолд нэн яаралтай хаалгах, өөрийн итгэлгүй хүндээ картаа өгөхгүй хувийн мэдээлэл нууц дугаараа хэлж өгөхгүй байх шаардлагатай. Мөн АТМ-аас мөнгө авахдаа арын хүндээ нууцдугаараа харуулахгүй байх, мессеж банкны үйлчилгээ идэвхижүүлж, гүйлгээгээ тухай бүрт нь хянадаг байх зэргээр сонор, сэрэмжтэй байхыг иргэддээ анхааруулж байна. Мөн цагдаагийн байгууллагын тусгай дугаар болох 105, 102, 103 дугаарт бага насны хүүхдүүд залгаж тоглох, хуурамч дуудлага өгөх тохиолдолд ихэссэн. Тухайлбал, есдүгээр сарын байдлаар 105 дугаарт 103 мянган дуудлага, мэдээлэл ирсэн. Үүний 71 хувь нь хуурамч дуудлага байсан. Харин 103 дугаарт 933 мянган иргэн дуудлага өгсний 17 хувь нь хуурамч байсан бол 102 дугаарт нэг сая 400 мянган дуудлага ирсэн. Үүний 19 хувь нь мөн л хуурамч дуудлага болох нь тогтоогдсон.

-Тусгай дугаарт хуурамч дуудлага өгсөн хүмүүсийг шалгасан уу. Ихэвчлэн ямар насны хүмүүс байна вэ?

-Тусгай дугаарт хуурамч дуудлага өгч байгаа иргэд ихэнх нь бага насны хүүхэд байгаа юм. Тиймээс цагдаагийн байгууллагаас хуурамч дуудлага өгсөн хүмүүсийг олж, хэрвээ хүүхэд байвал сануулж,

тайлбарлах, эцэг эхэд нь анхааруулах зэрэг арга хэмжээ авч байна. Тэгэхээр иргэддээ хандаж хэлэхэд, цагдаагийн байгууллагын тусгай дугаарт хуурамч дуудлага өгөхгүй байхыг хүсч байна. Хуурамч дуудлага өгснөөр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулж байна гэсэн үг.

-Банкны картны залилангийн хэрэгтнүүд манай улсаас өөр улсад гүйлгээ хийж байна гэсэн. Ихэвчлэн ямар улсад гүйлгээ хийгдэж байна вэ?

-Ихэвчлэн Зүүн өмнөд Азийн улсуудад гүйлгээ хийгдсэн байгаа.

-Эдгээр хэрэгт сэжиглэгдэж байгаа хүмүүс бий юу. Аль улсын иргэд вэ?

-Одоогийн байдлаар хоёр иргэнийг сэжиглэн шалгаж байна. БНХАУ-ын иргэд бий.

-Сонгуулийн үеэр цацагдсан 60 тэрбумын хэрэгт шалгалт хийж байгаа. Энэ хэргийн шалгалтын явц ямар байна вэ?

-“МАН-ын удирдлагуудтай холбоотой 60 тэрбум төгрөгийн бичлэгийн хэргийг шалгаж байна. Уг хэрэгт хоёр иргэнийг сэжигтнээр татан шалгаж байгаа. Хэргийн шалгалтын ажиллагаа үргэлжилж байгаа учраас дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй.

Жаргалант сумын нутагт нөхөн сэргээлт нэрээр олборлолт хийжээ

Баянхонгор аймгийн Жаргалант сумын “Мандал бүүргийн зүүн салаа”-ны зургаан га газарт нөхөн сэргээлт нэрээр уул уурхайн компани олборлолт хийсэн талаар Монголын бичил уурхайн нэгдсэн “Дэвэр” холбооны тэргүүн Б.Наранцогт, сургалт олон нийт харилцсан мэргэжилтэн Р.Түмэндэмбэрэл нар мэдээллээ. 2014 оны долдугаар сарын 16-наас есдүгээр сарын 15 хүртэл Баянхонгор аймгийн Жаргалант сумын “Мандал бүүргийн зүүн салаа”-ны зургаан га газарт бичил уурхайн нөхөрлөлийн гишүүд техникийн болон нөхөн сэргээлт хийн орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгсөн. Тус сэргээлт хийсэн газар өмнө нь алт, зэс олборлодог байсан ба олборлолт хийж дууссаны дараа тус газрыг биологийн нөхөн сэргээлтэнд оруулан орон нутагт нь хүлээлгэн өгчээ.

Гэтэл энэ оны есдүгээр сарын 7-ны орой “Буян-Цэцэн” ХХК нь нөхөн сэргээлт хийсэн газарт дахин нөхөн сэргээлт хийх гэж байна гэдэг нэрийн дор нутгийн иргэдэд худал хэлэн тус талбай руу дайран орсон байна. Тус компанийн энэхүү хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар Улсын мэргэжлийн хяналтын газар болоод хууль хяналтын байгууллагууд зохих арга хэмжээ авна гэдэгт итгэж байна хэмээн тус холбооны Сургалт олон нийт харилцсан мэргэжилтэн Р.Түмэндэмбэрэл ярилаа. Мөн тус аймгаар тогтохгүй Төв, Увс аймгуудад ийм хэрэг гарсан ч бид нотлох баримтыг улам сайжруулж байж мэдэгдэнэ гэсэн юм. Харин Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг дарга Д.Сайнбилэг орон нутгийн засаг захиргаанаас холбогдох зөвшөөрөл өгөөгүй байхад дур мэдэн үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын хууль тогтоомжийг уландаа гишгэж буй эдгээр компаниудтай тууштай тэмцэж, орон нутгаа хамгаална гэдгээ илэрхийлээд байна. Тэрбээр эдгээр компаниудад нэн даруй хууль бус ажиллагаагаа зогсоохыг шаардсан албан бичиг хүргүүлж өөрийн биеэр очиж уулзсан байна.

Хүчингүйд тооцов

0004528 гэрчилгээний дугаартай, Y2201000214 улсын бүртгэлийн дугаартай УБ хот, СХД, 1-р хороолол, 15-р хороо, 19-р байр 349 тоотод байрлах орон сууцны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

Ч.Баянжаргалын (регистрийн дугаар: ФЖ62031202) өмчлөгчийн Y-2205016024 Улсын бүртгэлийн дугаартай байрны гэрчилгээг гэсэн тул хүчингүйд тооцов.

С вирусийн эмчилгээнд 23.4 тэрбум төгрөг тусгав

Монголын элэгний эмч нарын нийгэмлэг, Оном сан, Өвчтөн нийгмийн төлөөллийн зөвлөл, Нэг Монгол ТББ элэгний өвчнөөс урьдчилан сэргийлэх “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ. Тэгвэл тус хөтөлбөр шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орж улмаар Монгол

Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3-т Элэгний хорт хавдар, хатуурын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварын тархалтыг таслан зогсоох зорилтын хүрээнд “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр үргэлжлэн хэрэгжихээр болжээ. Түүнчлэн Эрүүл

мэндийн даатгалын сангийн төсөвт 23.4 тэрбум төгрөг элэгний С вирусийн эсрэг эмчилгээ, оншилгоог хөнгөлөхөд тусгагдсан байна. Дашрамд дурьдахад манай улс 100 мянган хүн тутам дахь элэгний хавдрын нас баралтаар дэлхийд нэгдүгээрт ордог ажээ. Энэхүү үзүүлэлт нь дэлхийн дунджаас найм дахин илүү юм.

Амиа алдсан уулчны хэрэгт хоёр иргэнийг сэжигтнээр татжээ

Хангай нурууны оргилд гарах зорилгоор найзынхаа хамт Монголд ирсэн Их Британийн уулчин бусдад дээрэмдүүлж, амиа алджээ. Тодруулбал, Их Британийн уулчин, парашюотч нисэгч 53 настай Стив Нэш Монголд өөрийн хамтрагч Гарет Астоны хамт Улаанбаатараас баруун тийш 400 километрын зайтай, 3900 метрийн өндөр Хангай Нурууны оргилд гарах зорилгоор хүрэлцэн ирсэн байжээ. Улмаар тэд наймдугаар сарын 30-ны орой нутгийн иргэдийн гэрт хоноглож, маргааш нь аяллаа үргэлжлүүлэхээр төлөвлөсөн байсан ч, Гарет гэгчийн хуучин шарх сэдэрсэн тул аялалыг үргэлжлүүлэх боломжгүй болсон байна. Харин Стив ганцаараа цааш явжээ. Ийнхүү явахдаа мөнгөө дээрэмдүүлж, бусдын гарт амиа алдсан байдалтайгаар олдсон байна. Тэгвэл уг хэрэгтэй холбогдуулан цагдаагийн газраас очигдөр мэдээлэл хийлээ. Хэргийн талаар ЦЕГ-ын Хөвлөл мэдээллийн төвийн дарга, цагдаагийн хошууч Б.Баатархүү “Архангай аймгийн Хангай сумын Тэрх баг “Хандрагт” гэх газарт Англи улсын иргэн 53 настай Стивен Нэйш гэгч амиа алдсан талаарх мэдээлэл энэ сарын 01-ний 02.40 цагт Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн. Тус хэргийг Улсын мөрдөн байцаах газрын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, Архангай аймгийн ЦЕГ-тай хамтран ажлын хэсэг гарган, хэргийн газар дээр ажиллаж байгаа. Одоогоор энэ хэрэгт холбогдуулан хоёр иргэнийг сэжигтнээр татан, шалгаж байна” гэсэн юм.



PHOTO NEWS

Монгол улсын төрийн шагналт, Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар, Зууны манлай уртын дууч Налжирын Норовбанзадын нэрэмжит уртын дуучдын олон улсын анхдугаар уралдааны ялагчид тодорлоо. Уртын дуучдын олон улсын анхдугаар уралдааны А ангиллын ялагчаар Төв аймгийн харьяат, ҮДБЭЧ-ын уртын дуучин Ц.Түмэнжаргал, Б ангиллын гранпри шагналыг Налайх дүүргийн соёл урлагийн орфны уртын дууны багш Э.Хүрэлбаатар авсан байна. Шалгаруулалтад таван орны 201 мэргэжлийн болоод ардын авъяастан уртын дуучид, хөгжилчид А, Б гэсэн ангилалд өрсөлджээ.



СЭРЭМЖЛҮҮЛЭГ

БООМ ӨВЧНӨӨС БОЛГООМЖИЛ

Дорнод аймгийн Хэрлэн сумын Хашаатад малын боомын өвчлөл гарч хорно цэрийн дэглэм тогтоожээ. Мөн тус сумын иргэн Н-д боом өвчний шинж тэмдэг илэрч, аймгийн БОЭТ-ийн халдвартын тасагт тусгаарлан эмчилгээ хийж эхэлжээ. Үүнтэй холбогдуулан эмч нар дараах зөвлөмжийг хүргэлээ. Тус өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд боомын голомтот нутгийн малыг боомын эсрэг дархлаажуултад хамруулах, шалтгаан тодорхойгүй

мал үхсэн тохиолдолд аль ойр байгаа мал эмнэлгийн байгууллагад яаралтай мэдээлэхийг санууллаа. Мөн үхсэн малын мах, түүхий эд, арьс ширийг ашиглахгүй, бусдад худалдахгүй байх, хэрэв үхсэн малд хүрэх зайлшгүй шаардлага гарвал хамгаалах хувцас, халад, бээлий өмсөж занших, мах, сүүн бүтээгдэхүүнийг гүйцэт боловсруулж хэрэглэх, мах худалдан авахдаа малын гарал үүслийн гэрчилгээг тодруулах шаардлагатай гэв.

1500 айлыг цахилгаанаар хангана



Нийслэл хотод 6000 өрх цахилгаангүй амьдарч байгаа гэх судалгааг Эрчим хүчний яам гаргасан байна. Энэхүү асуудлыг шийдэхэд хөрөнгө мөнгөний бэрхшээл тулгарч байгаа тул эхний ээлжинд Баянзүрх дүүргийн 21, 27-р хорооны 1500 өрхийг цахилгаантай болгох ажил өнгөрсөн долоо хоногт эхэлжээ. Уг ажлыг хүйтний улирал эхлэхээс өмнө дуусгах төлөвлөгөөтэй байгаа аж. “Дараагийн ээлжинд мөн тооны айлыг эрчим хүчээр хангах ажил хийгдэнэ” гэж Эрчим хүчний сайд П.Ганхүү хэллээ. Цахилгаангүй байгаа 6000 өрхийн дийлэнх хувийг Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт оршин суудаг айлууд эзэлж байна.

МЭДЭЭЛЭЛ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



Цоо шинэ савлагаа, цоо шинэ хиам

Энэ бол BERLIN брэнд

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



Э.ЭНХЦЭЦЭГ

Монголчуудын өдөр тутамдаа хэрэглэдэг хүнсний гол бүтээгдэхүүн хиам гээд хэлчихэд хилсдэхгүй биз ээ. Өглөөний цай, өдрийн хөнгөн зууш гээд бид хиамыг хүнсэндээ өргөн хэрэглэх болсон. Тэгвэл бидний гол хэрэглээ болох мах, махан бүтээгдэхүүн буюу хиамны хэрэгцээг 1946 оноос хойш хангаж, түүхт 70 жилийнхээ ойтой золгож буй “Мах комбинат” буюу эдүгээгийн бидний мэдэх “Мах импэкс” ХК-ийн Хиам консервны үйлдвэр жил бүр хэрэглэгчиддээ шинэ бэлэг барьдаг. Саяхан тус компанийнхан малчдад төдийгүй иргэдэд хэрэгтэй хөтөлбөр хэрэгжүүлж буйгаамэдэгдсэн бол өчигдөр савлагааны шинэ үйлдвэрийн нээлтийн үйл ажиллагаагаа ёслол төгөлдөр хийлээ. Энэ жил 70 жилийн түүхт ойтойгоо золгож буй хүнсний ууган үйлдвэр “Мах импэкс” компанийн савлагааны шинэ үйлдвэрийн нээлтийн үйл ажиллагаанд олон хүндтэй зочид ирсэн юм. Тодруулбал, Монголын Хүнсчдийн холбооны тэргүүн, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих Зөвлөлийн дарга Л.Батнасан, Герман Монголын бизнес эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Герхард Вакенхут, ХХААХҮЯ-ны Хүнсний бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга Т.Гантогтох, мэргэжилтэн Ц.Цэцэгдарь, Нэвтрүүлэлтийн төвийн захирал Э.Энхээ, БНСУ-ын Бусонг болон SNSS компанийн Монгол дахь салбарын захирал С.Сүх-Очир, ХБНГУ-ын Multivac компанийн Азийн бүсийг хариуцсан техникийн зөвлөх, инженер Wilfried Streubel, МХЕГ-ын Хил хорио цэрийн улсын ахлах байцаагч Г.Элдэв-Очир, БНСУ-ын Хилийн чанад дахь хөдөө аж ахуйг дэмжих газрын дарга Хун Сон Гү, Технологийн дээд сургуулийн Мах боловсруулах үйлдвэрийн дарга О.Зориг, “Баянгол” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Цэндбаяр нар хүндэтгэл үзүүлэн, хүрэлцэн ирсэн байлаа.

Савлагааны шинэ үйлдвэрийн нээлтийн ёслолын үйл ажиллагааг “Мах импэкс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Будрагчаа нээж хэлсэн үгэндээ, “Манай компани энэ онд нэлээд хэдэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2016 он гарсаар бид ХБНГУ-д зохион байгуулагдсан олон улсын мах махан бүтээгдэхүүний олимпоос Хиам консервны үйлдвэрийн хамт олон “Нүүдэл” брэндийн бүтээгдэхүүнээр алтан медаль, “Дээдэс” нэрийн бүтээгдэхүүнээрээ мөнгөн медаль хүртсэн амжилттайгаар түүхт ойн жилээ

утгаж байна. Түүнчлэн савлагааны шинэ үйлдвэр буюу 2014 оноос төлөвлөн хэрэгжүүлж байгаа хиамыг жижиглэн савлах төслийг танилцуулахад бэлэн болоод байна. Уг төслийн хүрээнд ХБНГУ-ын Мултивак болон Текстор компанийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг суурилуулж, ашиглалтад оруулсан. Уг тоног төхөөрөмжийг суурилуулахад БНСУ-ын Бусонг болон SNSS компанийн хамт олон тусгай орчин бүрдүүлсэн.

Энэхүү савлагааны шинэ үйлдвэрийг байгуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн дотоодын болон гадаадын инженер техникийн ажилтнууд та бүхэнд хамт оныхоо өмнөө халуун талархал илэрхийлэе” хэмээсэн. Нээлтийн ёслолын үеэр савлагааны шинэ үйлдвэрийн талаар “Хиам консервний үйлдвэр”-ийн Гүйцэтгэх захирал Б.Бадмаа танилцуулсан. Хиамыг орчин үеийн стандартын дагуу жижиглэж савлах төсөл одоогоос хоёр жилийн өмнө эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд судалгаа хийж, олон улсад зохион байгуулагдсан үзэсгэлэнд оролцож туршлага хуримтлуулжээ. Ингээд үндсэн таван бүтээгдэхүүнийг сонгож, савлагаар болсон бөгөөд хамгийн сүүлийн үеийн савлагааны тоног төхөөрөмжөөс гадна, бэлэн бүтээгдэхүүнийг савлах тэр ариун орчныг бүрдүүлэхэд ихээхэн анхаарал хандуулсан байна. Ийнхүү төслийн үйл ажиллагаа амжилттай эхэлж, ХБНГУ-ын Мултивак болон Текстор компани, БНСУ-ын Бусонг болон SNSS компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, өнгөрсөн оны аравдугаар сараас ажилдаа ханцуй шамлан орж, эдүгээ шинэ савлагаатай шинэхэн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдийн гарт хүргэж эхлээд байгаа аж.

Цоо шинэ үйлдвэртэй танилцах зуур “Хиам консервний үйлдвэр”-ийн Гүйцэтгэх захирал Б.Бадмаатай цөөн хором ярилцлаа. Тэрбээр “Энэхүү үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадлын тухайд цагт нэг тонн орчим бүтээгдэхүүн зүсэх, савлах хосолмол ажиллагаатай, өдөрт 8-10 тонн бүтээгдэхүүн гаргах боломжтой. Үнэ өртгийн хувьд зөвхөн энэ машин тоног төхөөрөмж гэлтгүй орчныг бүрдүүлэхэд нэлээд хөрөнгө зарсан. Ойролцоогоор гурав орчим тэрбум төгрөгийн хөрөнгөөр энэхүү үйлдвэр бүтсэн. Өнөөдөр “Мах импэкс” компанийн шинэ үйлдвэрээс Берлин нэрийн таван төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гарч байна. Энэ таван төрлийн бүтээгдэхүүнийг шинэ савлагааны үйлдвэртээ зүсч, савлаж хэрэглэгчиддээ хүргэж эхлээд байна. Энэхүү савлагаагаар савласан бүтээгдэхүүнийг Европын улсад

40-60 хоног хадгалах боломжтой байдаг. Одоохондоо бид Монгол Улсынхаа стандартад захирагдаад хамгийн боломжтой хугацаа буюу долоо хоног хадгална гэж хадгалалтын хугацаагаа тавьчихаад байна” хэмээсэн юм.

Цоо шинэ хэмээн онцолсон Berlin брэндийн “Зүрхтэй чанамал хиам”, “Тахианы цэж махтай”, “Чанамал хиам”, “Тахайн гуяны махтай”, “Сармист утлагат хиам” хэмээн таван төрлийн хиамыг 200 граммаар савлажээ. Түүнчлэн савлагааны шинэ үйлдвэрийн нээлтийн үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн хүндэт зочид сэтгэгддээ илэрхийлэхийн зэрэгцээ Мултивак болон Текстор компанийн тоног төхөөрөмжийг хослуулан хэрэглэж буйгаараа Монголд төдийгүй Азидаа анхдагч болж буй “Мах импэкс” компанийнханд талархаж буйгаа илэрхийлж байлаа. Үүний баталгаа болгож, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхэт элчин сайд Штефан Дуппелийг төлөөлөн энэхүү ёслолын ажиллагаанд хүрэлцэн ирсэн Герман Монголын бизнес эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Герхард Вакенхут баяр хүргэж, батламж гардуулсан юм. Мөн энэ үеэр БНСУ-ын Бусонг болон SNSS компанийн Монгол дахь салбарын захирал С.Сүх-Очир, ХБНГУ-ын Multivac компанийн Азийн бүсийг хариуцсан техникийн зөвлөх, инженер Wilfried Streubel нарт Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын жуух бичигийг Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих Зөвлөлийн дарга Л.Батнасан гардуулсан. Шагналын хур үүгээр дууссангүй. Жижиглэн савлах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлж, хамт олноо амжилттай удирдан зохион байгуулсан тус компанийн технологич Б.Амарбаяр МЗХ-ны “Тэргүүний залуу” алтан медалийг “Хиам консервний үйлдвэр”-ийн Гүйцэтгэх захирал Б.Бадмаа гардуулсан. Мөн ХБНГУ-ын Франкфурт хотноо болсон олон улсын мах, махан бүтээгдэхүүний үзэсгэлэнд “Мах импэкс” компанийн “Хиам консервний үйлдвэр”-ийн хамт олон амжилттай оролцож, анх удаа монгол хиам, махан бүтээгдэхүүн дэлхийн нэр хүндтэй тус үзэсгэлэнгээс алт мөнгөн медаль хосоор нь авсан амжилтыг нь үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус компанийн ерөнхий технологич Р.Отгонд “Алтан гадас” одон хүртээснийг Монголын Хүнсчдийн холбооны тэргүүн, УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва гардуулсан юм. Ийнхүү шагналун хур буусан цэлмэг сайхан өдөр цоо шинэ савлагаатай, цоо шинэ хиам Берлин брэнд хэрэглэгчдийн гарт хүрч эхэллээ.